

## Монгол-Хятадын соёл, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн харилцааны асуудалд

Ч.Батцэцэг<sup>1\*</sup>

Ц.Ариунаа<sup>2\*</sup>

*Товч агуулга: Эл өгүүлэлд Монгол, Хятад хоёр улсын хоорондын соёл хүмүүнлэгийн харилцааны талаархи эрхзүйн орчны нөхцөл байдал, ялангуяа өнөөгийн стратегийн түншлэлийн харилцааны хүрээнд хоёр орны соёл, боловсрол, шинжлэх ухаан зэрэг салбарын хамтын ажиллагааны үйл явц, бүс нутаг, ард иргэдийн хоорондын харилцаа хэрхэн өрнөж буй тухай бичсэн болно.*

*Abstract: The paper explores the legal environment of cultural and humanitarian relationship between China and Mongolia, particularly within the present strategic partnership, the process of regional and communal relationship and collaboration of the two countries on education, science, culture and tourism.*

**Түлхүүр үгс:** гэрээ хэлэлцээр, соёлын солилцоо, соёлын өдрүүд, боловсрол, орон нутаг, харилцаа, хамтын ажиллагаа

**Key words:** agreements, cultural exchange, cultural days, regional relationship, collaboration

---

<sup>1\*</sup> ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн э/ш ахлах ажилтан, доктор (Ph.D)

<sup>2\*</sup> ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн э/ш ажилтан.

\* \* \*



Монгол, Хятадын хоорондын соёл хүмүүнлэгийн харилцааны асуудлыг авч үзэхүл, 90-ээд оноос Монгол, Хятад хоёр улс стратегийн түншлэлийн харилцаа байгуулах үе хүртэлх хугацаанд хоёр улсын соёл хүмүүнлэг, шинжлэх ухаан, боловсролын салбарт маш олон гэрээ хэлэлцээр байгуулж, санамж бичигт гарын үсэг зурснаар соёл хүмүүнлэгийн харилцаа цаашид тасралтгүй өргөжин хөгжих хууль эрхзүйн орчны таатай нөхцөл бүрдэж, баталгаажсан юм. Тухайлбал: “Монгол Улс, БНХАУ-ын соёлын хамтын ажиллагааны гэрээ” (1994 он), “Монгол Улс, БНХАУ 1998-2000 онд соёлын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төсөл” (1998 он), “Биеийн тамир, спортын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “Боловсролын үнэмлэх, эрдмийн гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Монголын оюутнуудыг сургах төслийг хэрэгжүүлэх хөтөлбөр” (2000 он), “Монгол Улс, БНХАУ 2001-2003 онд соёлын солилцоо, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төсөл” (2001 он), “Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газраас 2004-2006 онд соёл урлагийн салбарт хамтран ажиллах ажлын төлөвлөгөө”, “Монгол Улс, БНХАУ 2005-2010 онд боловсролын солилцоо, хамтын ажиллагааны хөтөлбөр,” “Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2010-2013 онд хэрэгжүүлэх соёлын солилцооны төлөвлөгөө” тус тус байгуулж гарын үсэг зурсан байна.

Хоёр орны соёлын харилцаа, хамтын ажиллагааны хэлбэр нь хоорондоо дипломат харилцаа тогтоосон цагаас эхлэн эдүгээ хүртэл хоёр орны тэмдэглэлт ойн хүрээнд “соёлын өдрүүд”-ийг харилцан явуулж, уг арга хэмжээний хүрээнд кино-өдөр, уран зургийн болон гэрэл зургийн үзэсгэлэн, концерт, циркийн үзүүлбэр зэрэг хэлбэрээр хэрэгжиж, хоёр орны ард түмэнд өөрийн улс орны үндэсний соёл урлагийн онцлогийг харуулах ажлыг голлож ирсэн юм.

2011 онд Монгол-Хятадын хооронд стратегийн түншлэлийн харилцаа байгуулагдсанаар хоёр орны харилцаа зарчмын шинэ шатанд

гарах эхлэл тавигдсан юм. БНХАУ-ын Соёлын сайд Цай У-гийн 2013 оны 9-р сард Монгол Улсад хийсэн айлчлал нь манай хоёр орны соёл, урлаг хүмүүнлэгийн салбарын цаашдын хамтын ажиллагааны нөхцлийг сайжруулахад ихээхэн тус дэм болсныг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг 2013 оны 10-р сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийх үеэр БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Кэцянтай “Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд урт хугацааны хөтөлбөр”<sup>1</sup>-т гарын үсэг зурав. Энэ баримт бичигт хоёр орны улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, аюулгүй байдал, худалдаа санхүү, тээвэр холбоо, соёл шинжлэх ухаан, хүмүүнлэг зэрэг олон салбар дахь хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон юм. Уг хөтөлбөрт: “хоёр улсын Засгийн газар хоорондын соёлын солилцооны төлөвлөгөөг идэвхтэй хэрэгжүүлэн, хоёр улсын аймаг, орон нутаг, олон нийтийн байгууллага хоорондын олон төрөл, хэлбэрийн соёл, урлагийн солилцооны үйл ажиллагааг дэмжих; хоёр талын арилжааны тоглолтыг дэмжиж, соёл урлагийн солилцоог нэмэгдүүлэх; соёлын сар, соёлын долоо хоногийн арга хэмжээг харилцан зохион байгуулах; орон нутаг хооронд соёлын өдрүүдийн арга хэмжээг харилцан зохион байгуулахыг дэмжих; соёл, урлагийн хамтлагууд нөгөө улсад зохиогдох олон улсын соёл, урлагийн арга хэмжээнд оролцохыг дэмжих; Монголын тал Улаанбаатар дахь Хятадын соёлын төв болон Күнзийн сургуулийн үйл ажиллагааг дэмжих; Хятадын тал Бээжин хотод Монголын соёлын төв байгуулахыг дэмжих; шилдэг бүтээлүүдийг орчуулах, хэвлэх, ном болон дуу, дүрс бичлэгийн үзэсгэлэн худалдааг харилцан зохион байгуулах, хоёр талын хэвлэлийн байгууллагууд олон улсын номын үзэсгэлэнд оролцохыг дэмжих; номын сан, музейн хоорондын үзэсгэлэн харилцан зохион байгуулах, ном, судар хадгалах болон мэргэжилтнүүдийг сургах чиглэлийн солилцоо, хамтын ажиллагааг урагшлуулах; дэлгэцийн шилдэг бүтээлүүдийг нөгөө талын зах зээлд гаргахад дэмжлэг, туслалцаа үзүүлж, телевизүүд кино, хөтөлбөр харилцан солилцох хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих; хоёр улсын соёлын биет бус өвийг хамгаалах хамтын ажиллагааны механизмыг бэхжүүлж, биет бус соёлын өвийг хамтран хамгаалах, бүртгүүлэх зэрэг чиглэлд хамтын

<sup>1</sup>“ Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд урт хугацааны хөтөлбөр” 2013.10.23. Бээжин хот.

## ОЛОН УЛС СУДЛАЛ

ажиллагаагаа бэхжүүлэх; түүхийн дурсгал, соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, холбогдох боловсон хүчинг бэлтгэх хамтын ажиллагааг эрчимжүүлэх тухай заалт оруулсан. Ийнхүү хоёр орны хоорондын соёл хүмүүнлэгийн харилцааны хүрээнд хийж гүйцэтгэж болох бүхий л ажлын чиглэлийг нэгбүрчлэн нэрлэж зааж өгснөөр энэ салбарын цаашдын харилцааны үйл явцыг улам бататган тодорхойлж, өргөжүүлэн хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж байгаа хэрэг юм.

Улмаар 2014 онд тохиож буй хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойг тэмдэглэх хүрээнд хэрэгжүүлэх “Монгол-Хятадын соёл, урлаг, хүмүүнлэгийн солилцооны жил”-ийн ажлын төлөвлөгөөг<sup>4</sup> баталсан нь стратегийн түншлэлийн харилцааны дунд урт хугацааны хөтөлбөрт тусгагдсан ажлуудын эхлэл болов.

2013 оны 11-р сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны 3-р бүгд хурлын шийдвэрт: гадаадтай соёлын солилцоогоо өргөжүүлэх, Хятадын соёлыг дэлхийд танин мэдүүлэхэд тус дөхөм үзүүлэх; гадаад руу хандсан соёлын аж ахуйн нэгжийг бэлтгэж, улмаар уг нэгжийг хилийн чанадад ажиллахыг дэмжих; Күнзийн институт болон гадаадын соёлын төвийн байгуулалтад оролцохыг дэмжих, хүмүүнлэгийн солилцооны төслийг хариуцах; гадаадын бүх шилдэг соёлын үр бүтээгдэхүүнийг идэвхитэй судалж, соёлынхоо хөгжилд ашиг тустай мэргэжилтэн, технологи, үйл ажиллагааг удирдах туршлагыг татан оруулах; төрийн соёлын аюулгүй байдлыг батлан хамгаалах тухай заасан.<sup>5</sup>

БНХАУ-ын эдүгээ эрчимтэй хэрэгжүүлж буй “соёлын зөөлөн хүч”-ний бодлогын тухайд авч үзэхүл, Хятад нь 2004 оноос соёлын бодлого, хүрээгээ гадагшаа өргөжүүлэн тэлж эхэлсэн байдаг. Харин “соёлын зөөлөн хүч” гэсэн нэр томъёог анх 2007 онд хуралдсан Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын /БХАТИХ/ илтгэлд тусгажээ. Тэр илтгэлд, БНХАУ соёлын гадаад бодлогоо улс төр, эдийн засгийн гадаад харилцаатай адил түвшинд эн тэнцүү тавьж, гадаад харилцааны гурван тулгуур гэж нэрлэсэн байна. Улмаар Хятадын соёлыг дэлхийд түгээх, олон улс дахь нэр нөлөөгөө нэмэгдүүлэхийн сацуу “энх тайвнаар хөгжих”, “Эв зохистой нийгмийг хамтаар

<sup>4</sup> [www.mongolchamber.mn](http://www.mongolchamber.mn)

<sup>5</sup> 中共中央关于全面深化改革若干重大问题的决定 (2013年11月12日中国共产党第十八届中央委员会第三次全体会议通过) ХКН-ын ТХ-ны 3-р бүгд хурлын шийдвэр. 2013 он.

байгуулах” гэсэн үзэл санаагаа сурталчлахыг гол зорилгоо болгов. Юуны өмнө БНХАУ-ын соёлын бодлого дахь стратегийн нэг чухал асуудал бол гадаадад “Күнзийн сургууль”, Хятадын соёлын төвийг байгуулах явдал юм. Энэ нь хятадын хэл, соёлыг тухайн оронд нэвтрүүлэн таниулах сурталчилгааны гол хэрэгсэл болдог. Күнзийн сургуулийн үйл ажиллагаа нь тухайн сургууль байгуулагдсан газар зөвлөх багш илгээх, сургалтын материалаар хангах, хилийн чанадад хятад хэл сургах, хятад хэлний багш бэлтгэх, оюутны сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх, хятадын соёлыг сурталчлахад чиглэгддэг. Манай улсад 2007 онд анх МУИС-ийн дэргэд Күнзийн институт байгуулагдсан бөгөөд 2013 он хүртэл хэдэн зуун оюутан сурагч энд суралцаж байна. МУИС дахь Күнзийн сургууль үйл ажиллагаагаараа шалгарч, 2010 онд дэлхийн Күнзийн сургуулиудаас тэргүүн байрыг эзэлжээ.

Хоёр улсын стратегийн түншлэлийн дунд, урт хугацааны хөтөлбөрийн “Боловсрол, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа” хэмээх зүйлийн хоёрдугаар заалтад: 1. “Ирэх 5 жилд хятадын тал жил бүр Монголын 1000-аас доошгүй оюутанд Хятадын Засгийн газрын тэтгэлэг олгох бөгөөд түүний дотор бакалаврын зэрэг горилох оюутны тоог 200-аас доошгүй байлгана” гэж оруулжээ. Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээний дагуу одоо жилд 300 оюутныг Хятадад сургадаг байсан бол энэ тоог гурав дахин нэмэхээр болж, таван жилийн хугацаанд жилд 1000 оюутныг төрийн тэтгэлгээр сургахаар болов. Үүний сацуу ӨМӨЗО-ы Засгийн ордны тэтгэлгээр 2005 оноос эхлэн жил бүр 100 оюутныг Өвөр Монголын бүх аймаг хотод суралцуулахаар болсон бөгөөд 2013 он хүртэл 2000 гаруй оюутан суралцаж төгсгөжээ. Мөн заалт 2. “Хятадын тал Монгол дахь хятад хэлний сургалтыг дэмжиж, Монголд илгээдэг хятад хэлний сайн дурын багш нарын тоог нэмэгдүүлэх, монголын талтай хамтран Монголын их, дээд, тусгай мэргэжлийн сургуулиудад хятад хэлний багш бэлтгэх анги эсвэл хятад хэлний бэлтгэл анги нээх, сурах бичиг, сургалтын материал нийлүүлэх, зохиох чиглэлээр дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд бэлэн байна” гэсэн зүйл оруулжээ. Гэтэл энэ хөтөлбөрийг хоёр улс адил тэнцвэртэй хэрэгжүүлэх ёстой боловч манай талаас энд тусгасан зүйл заалт оруулаагүй тал ажиглагдаж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад 41 их дээд сургуульд хятад хэлний сургалттай анги нээсэн, тухайлбал, орон нутагт Дорнод, Ховд, Дархан, Замын-Үүд зэрэг аймаг хотын бага дунд сургуульд хятад хэлний ангийг нээж, тэднийг Хятадын засгийн газраас дэмжиж урамшуулан тэтгэлэг олгож, хятад хэлний сайн дурын багш нарыг томилж ажиллуулж байна.

Монгол, Хятад хоёр улс 2010 оны 5-р сарын 1-ний өдөр “Монгол Улс болон БНХАУ-ын Засгийн газрын харилцан соёлын төв байгуулах тухай гэрээ” байгуулсны үндсэн дээр 2011 онд Улаанбаатар хотод Хятадын соёлын төвийг байгуулав. 2011-2013 оны хооронд энэ соёлын төвөөр дамжуулж Хятадын Тяньжин, Хармөрөн, Шаньси, Өвөр Монгол, Чуньцин, Шанхай, Гирин зэрэг муж хотын орон нутгийн төлөөлөгчид, хамтлаг, нэгж Монгол Улсад зочилж, бүс нутгийнхаа соёлыг харуулах, лекц унших, тоглолт хийх, үзэсгэлэн гаргах, эрдэм шинжилгээний хурал хийх зэрэг олон арга хэмжээг зохион байгуулж ирэв.

Монгол, Хятадын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Мөн хоёр улс “Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг»-т гарын үсэг зурсан. Хөтөлбөрт Монголд анхны шинжлэх ухааны парк байгуулж, хөгжүүлэхэд туршлага судлах, хамтарсан төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, оюутан болон эрдэмтэн солилцоог дэмжих, хоёр талын шинжлэх ухаан, технологи, инновацийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд энэ хамтын ажиллагаа чиглэнэ<sup>6</sup> гэж заасан.

Өнөөдөр Монгол Улсад хэрэгжиж байгаа шинэчлэлийн Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016 оны хөтөлбөрт: үндэсний соёл, урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг дээшлүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах замаар монгол үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой нийцүүлэн хөгжүүлэх; соёл урлагийн салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгох; түүх, палеонтологи, археологийн олдворыг онцгойлон хадгалж хамгаалах; соёлын өвийг

<sup>6</sup> <http://www.zasag.mn/news/view/3442#sthash.PQK9ZC9R.dpuf>

эрэн сурвалжлах, судлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлан түгээх үндэсний чадавхийг нэмэгдүүлэх; соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэ шатанд гаргаж, улсын нэгдсэн бүртгэлийн цахим мэдээллийг хил, гааль, цагдаа, мэргэжлийн хяналтын дотоод сүлжээтэй холбох тухай зааж<sup>7</sup> үндэснийхээ соёл урлагийн салбарын үйл ажиллагааг тодорхойлсноор зарим ажлууд биеллээ олж байна.

Ялангуяа Монгол Улсад соёлын өвийг хадгалж, хамгаалах асуудал хурцаар тавигдаж, ялангуяа соёлын эд зүйлс буюу хөдлөх соёлын өвийн хулгай, дамлан худалдаалах явдал эрс нэмэгдэж байгаа нь зөвхөн манай улсын төдийгүй эрчимтэй даяарчлагдаж буй дэлхий дахины сэтгэл зовоосон асуудал болж байна. Үүнээс улбаалан 2011 онд байгуулсан “Соёлын өвийг хууль бусаар хил давуулах, соёлын дурсгалт газар хууль бусаар малтлага хийх, түүх соёлын дурсгалт зүйлсийг хулгайд алдагдахаас сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр” тусгалаа олж байна.

БНХАУ нь гадаад бодлогынхоо хүрээнд хөрш орнуудтай харилцах үзэл баримтлалаа баяжуулан, хөрш орны талаархи бодлогоо улам тодорхой болгож, ялангуяа хил орчмын хөрш орнуудтай найрсаг харилцаагаа бүхий л талаар хөгжүүлэн бэхжүүлж, харилцан ашигтай, аюулгүй хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн, ард иргэд, соёлын харилцааг улам нягтруулахад хүчин чармайлт гаргах шаардлага байгаа тухай<sup>8</sup> БНХАУ-ын дарга Си Зиньпин хэлсэн юм.

Монгол-Хятадын соёлын харилцаа, хамтын ажиллагааны хүрээ үндсэндээ нийт улсын хэмжээнд гэхээсээ илүүтэй бүс нутгийн шууд харилцаа буюу хил орчмын монгол үндэстний хооронд орон нутгийн хэмжээнд өргөн дэлгэр явж ирсэн гэхэд хилсдэхгүй. Энэ харилцаа цаашид ч улам өсөх хандлагатай болж байна. Ийнхүү Монгол-Хятадын харилцаа, хамтын ажиллагаанд Өвөр Монголын өөртөө засах орон, түүн дотор өвөр монголчууд чухал үүрэг гүйцэтгэж, хоёр талын ард иргэд бүх чиглэлээр хоорондоо харьцаж байгааг онцлон тэмдэглэж

<sup>7</sup> www.zasag.mn

<sup>8</sup> Хил хязгаарын гадаад үйл ажиллагааны талаарх зөвлөгөөн дээр Си Зиньпиний хэлсэн үг “Renmin wanbao”. 2013.10.26. Бээжин хот

байна.

2005 онд Монгол Улс, БНХАУ-тай хамтарч монгол үндэстний уртын дууг ЮНЕСКО-д бүртгүүлж, дэлхийн түүх, соёлын өв санд үнэтэй хувь нэмэр оруулсан монгол үндэстэн, нүүдэлчдийн соёл иргэншлийг дэлхий дахинд таниулах анхны алхам боллоо гэж хоёр тал үзсэн. Дараа нь 2009 онд БНХАУ дангаараа монгол үндэстний хөөмийг Хятад улс бие даан ЮНЕСКО-д бүртгүүлсэн нь манай хоёр орон улмаар монголчуудын дунд үл ойлголцлыг бий болгосон юм. БНХАУ-д аж төрдөг монгол үндэстний ард иргэд ч гэсэн бидний нэгэн адил үндэстнийхээ зан заншил, соёлын өв, эд өлгий, баялаг уламжлалаа хадгалсаар өдгөө хүрсэн билээ. Гэхдээ Өвөр Монголд монгол үндэстний язгуур болон орчин үеийн соёл урлагийг баяжуулан, дэлгэрүүлэн хөгжүүлэхэд нэг талаас Монгол Улсын соёл, урлагийн нэрт зүтгэлтнүүд, мэргэжилтэн, багш нарын оруулсан хувь нэмэр асар их, нөгөө талаас Өвөр Монголоос манай оронд оюутан сурагчид олноороо ирж идэвхтэй, хичээнгүй сайн суралцаж байгаагийн үр дүн гэдгийг хэлэх хэрэгтэй. Үүнээс улбаалан хоёр улсын хооронд "Соёлын биет бус өвийг хамгаалах тухай харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулсан юм.

Хоёр улсын стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрт: "янз бүрийн шугамаар залуучуудын солилцооны арга хэлбэрийг баяжуулна" гэж заасан. Үүний үндсэн дээр Хятадын засгийн газраас манай залуучуудын ажил мэргэжлийн байдлыг харгалзан, тухайлбал эхлээд сэтгүүлчдийг, бизнес эрхэлдэг залуусыг, намын залуу боловсон хүчнийг гэх зэргээр хэдэн арваар нь урьж хятадын эдийн засгийн хөгжлийг таниулан сурталчлах ажлыг идэвхтэй эхлүүлээд байна. Манай улсад ч мөн энэ зун /2014 он/ Хятадаас бизнес эрхэлдэг залуус олноороо ирсэн юм. Энэхүү залуучуудын солилцооны гол зорилго бол хоёр орны залуусыг ойртон нөхөрлүүлэх, үндэсний онцлог, хөгжлийн үйл явцыг харуулах, хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх явдал юм. Гэхдээ нөгөө өнцгөөс харахад, монголын хойч ирээдүй болсон залууст хятадын тухай илүү эерэг ойлголт, харьцангуй таатай, нааштай, сэтгэгдэл төрүүлснээр хятадын эсрэг үзлийг намжаахад чухал алхам болно хэмээн хятадын тал үзэж байгаа нь илт байна.

Угаас улс орон, ард түмний хоорондын ойлголцол, итгэлцэл, нөхөрлөлийг бэхжүүлэхэд соёл хүмүүнлэгийн бодит харилцаа чухал үүрэг гүйцэтгэх ач холбогдолтой байдаг. Хоёр орны соёл хүмүүнлэгийн харилцааны хүрээнд соёлын солилцоог эрчимжүүлэх шаардлагын талаар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Ван Сяолун “хоёр талын соёл урлагийн хамтын ажиллагааг маш ихээр хөгжүүлэн эрчимжүүлэх нь хоёр талын улс төрийн ойлголцлыг цаашид тогтвортой бэхжүүлэхэд таатай сайхан нөхцөл, боломжийг бүрдүүлэх болно”<sup>9</sup> гэж хэлсэн үг дээрхийг нотолж байгаа юм.

### Ном зүй

1. Ч. Батцэцэг. Монгол Улстай хил залгаа бүс нутаг УБ., 2007 он
2. 中蒙俄：和平发展与合作。北京, 2009 он. Ч.Батцэцэг. Культурное сотрудничество как возрастающий фактор углубления взаимопонимания трёх стран.
3. 第六届中俄蒙区域经贸合作论坛 2012.07 中国。满洲里。БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотод болсон Хятад-Орос-Монголын бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны 6 дахь удаагийн форум. Ч.Батцэцэг. “Монгол-Хятадын хил орчмын бүс нутгийн харилцаа: соёл, аялал жуулчлалын салбарын асуудалд” илтгэл.
4. “Гадаад хэл соёл судлал” эрдэм шинжилгээний бичиг 2012№363 /16/. Т. 228-234. Ч.Батцэцэг “Өвөр Монгол хоёр улсыг холбох гүүр мөн үү?” э/ш өгүүлэл
5. 蒙中关系65周年：展望学术研讨会.中国.呼和浩特., 2014.05.18-19 Ч.Батцэцэг.Монгол-Хятадын соёл хүмүүнлэгийн харилцаа-65 жилд.
6. ”Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд урт хугацааны хөтөлбөр” 2013.10.23. Бээжин хот.
7. “蒙古消息报” сонин.
8. “Солонго” сэтгүүл. 2004-2014 оны дугаар.

<sup>9</sup> Улаанбаатар хотод болсон хоёр улсын соёлын арга хэмжээнд хэлсэн үг. 2012.9-р сар